





ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГАД ОРОХ ӨӨРЧЛӨЛТ





#### 4.1. Бонд гаргах эрх бүхий этгээдийн шийдвэр

Үнэт цаас гаргагчийн төрийн мэдлийн хувьцааны эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийг Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан томоохон төслүүд болох төмөр зам, цахилгаан станц, сайжруулсан түлшний төслийн санхүүжилтыг шийдвэрлэх зорилтын хүрээнд дотоодын зах зээлд бонд гаргах асуудлыг дэмжиж буйгаа илэрхийлсэн байна. Мөн Сангийн яам болон Хууль зүй, дотоод хэргийн яамтай зөвшилцөн дараах санал, чиглэлийг ирүүлсэн байна. Үүнд:

Дотоодод гаргах үнэт цаасыг компанийн хэрэгжүүлэх төслүүдийн хэрэгжилттэй уялдаатайгаар үе шаттайгаар нээлттэй хэлбэрээр гаргах, дунд хугацаанд компанийн үйл ажиллагааны ашигт нөлөөлөх зардал, эрсдэлийн шинжилгээг нарийвчлан хийсний үндсэн дээр шинээр гаргах үнэт цаасын эргэн төлөх төлөвлөгөөг нарийвчлан тооцож, тухайн үнэт цаасны эргэн төлөлттэй холбоотой аливаа хугацаа хэтэрсэн болон болзошгүй өр төлбөр үүсгэхгүй байхад анхаарах чиглэлийг өгсөн байна.

Хавсралт 56. УУХҮЯ-ны 2021 оны 02 сарын 10-ны өдрийн 01/346 тоот албан бичиг

Хавсралт 57. ХЗДХЯ-ны 2021 оны 02 сарын 09-ны өдрийн 1/651 тоот албан бичиг


Хавсралт 58.СЯ-ны 2021 оны 02 сарын 09-ний өдрийн 8-1/480 тоот албан бичиг

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 сарын 02-ны өдрийн хурлын 03 тоот тогтоол /Хавсралт 59/-ын дагуу үнэт цаас гаргах шийдвэрийг гаргасан байна.

1. Тавантолгой ордыг түшиглэн хэрэгжүүлэх томоохон төсөл, хөтөлбөрүүдэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх, компанийн үндсэн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2.0 (хоёр их наяд) хүртэлх төгрөгийн өрийн бичгийг нийтэд санал болгон гаргахыг Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт зөвшөөрсүгэй.
2. Өрийн бичиг гаргах бэлтгэл ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хангах, үнэт цаасны танилцуулга, бусад баримт бичгийг боловсруулах болон татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг тухай бүр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Ганхуягт үүрэг болгосугай.
3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Ү.Амарбат)-нд даалгасугай.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 сарын 18-ны өдрийн хурлын 06 тоот тогтоол /Хавсралт 73/-ын дагуу үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулах шийдвэрийг гаргасан байна.

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 07 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “өрийн бичиг гаргах нөхцөл”-ийн “Жилийн хүү” гэсэн нөхцөлд оруулах өөрчлөлтийг энэ тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоол батлагдсантай холбоотойгоор “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн “Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 40 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.





3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан үнэт цаасны нөхцөл өөрчлөхтэй холбоотой гарах зардлуудыг компанийн 2022 оны төсвийн тодотголд оруулсугай.
4. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо (Ү.Амарбат)-нд даалгасугай.

#### 4.2. Бондын нөхцөл

“Эрдэнэс Тавантолгой” ХК нь дараах нөхцөл бүхий бондыг нээлттэй нийтэд санал болгож байна.

Үнэт цаас гаргагч	“Эрдэнэс Тавантолгой” Хаалттай ХК
Үнэт цаасны төрөл	Өрийн хэрэгсэл
Үнэт цаасны арилжаа	Нийтэд нээлттэй санал болгох
Нэгжийн нэрлэсэн үнэ	Төгрөгийн бонд: 100,000 төгрөг Долларын бонд: 100 доллар
Нийт тоо ширхэг	20,000,000 ширхэг хүртэлх
Нийт үнийн дүн /хүртэлх/	2,000,000,000,000 төгрөг хүртэлх /төгрөг, ам.доллар хосолсон/
Жилийн хүү	Төгрөг: хүү олгох өдөр мөрдөгдөж буй Монгол Банкнаас зарласан бодлогын хүү + 4% хүртэл* Ам.доллар: 6.8%
Хүү төлөх хугацаа	Хагас жил тутам
Хугацаа	24-36 сар
Эргүүлэн авах нөхцөл	Хугацаанаас өмнө эргэн дуудах нөхцөлтэй
Үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацаа хэтрэлт	Хүү төлөх өдрөөс хугацаа хэтэрсэн хоног тутамд хүүгийн төлбөрөөс 0.02%-р алданги нэмж тооцон хүүг алдангийн хамт Үнэт цаас эзэмшигчид төлнө
Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт	Бүтээн байгуулалтын төслүүдийг санхүүжүүлэх
Баталгаа	Борлуулалтын орлого
Арилжаалах зах зээл	Монголын хөрөнгийн бирж ТӨХК
Хадгаламж, бүртгэл төлбөр тооцоо	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК
Андеррайтер	Андеррайтер: MICC ҮЦК ХХК

\*2022 оны 3 дугаар сараас хойш олон нийтэд санал болгож буй бондод хамааралтай.





**Хавсралт 73. Төлөөлөн удирдах зөвлөлийн үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулах тухай тогтоол**



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

**Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 76 дугаар зүйлийн 76.1.5, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.7, 8.6.10 дахь заалт, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 21/03 дугаар тогтоол, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 03, 07, 40 дүгээр тогтоол, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 8-1/480, 2021 оны 8-3/1321 тоот албан бичиг, "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч "Эрдэнэс Монгол" ХК-ийн 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 01/145 тоот бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 07 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өрийн бичиг гаргах нөхцөл"-ийн "Жилийн хүү" гэсэн нөхцөлд оруулах өөрчлөлтийг энэ тогтоолын хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоол батлагдсантай холбоотойгоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн "Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулах тухай" 2021 оны 40 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан үнэт цаасны нөхцөл өөрчлөхтэй холбоотой гарах зардлуудыг компанийн 2022 оны төсвийн тодотголд оруулсугай.
4. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороо (Ү.Амарбат)-нд даалгасугай.

ДАРГА




Д.БАТБААТАР





"Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн  
Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн  
06 дугаар тогтоолын хавсралт



Өрийн бичиг гаргах нөхцөлд оруулах нэмэлт, өөрчлөлт

Жилийн хүү	Төгрөг (хувьсах хүү): Хүү олгох өдөр мөрдөгдөж буй Монгол банкнаас зарласан бодлогын хүү+4% хүртэл
	Ам.доллар: 6.8% хүртэл





**“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт болон шаардлагатай төлбөрийн мэдээлэл**


“Эрдэнэс Тавантолгой” ХК нь 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны 96 тоот тогтоолоор компанийн өрийн хэрэгслийг бүртгүүлж, 2 их наяд төгрөг хүртэлх бондыг нийтэд үе шаттайгаар санал болгох зөвшөөрөл авсан. Үүнээс хойш анхдагч зах зээл дээр ЭТТ Бондыг санал болгож, олон нийтээс 692.5 тэрбум төгрөг татан төвлөрүүлээ.

Бондын хүүгийн төлбөрт 2021 оны 10 дугаар сарын 7-нд 11,795,180,657.53 төгрөг, 1,322,780.79 ам.долларыг, 2022 оны 2 дугаар сарын 23-нд 8,201,024,712.33 төгрөг, 385,218.81 ам.долларыг, нийт, 19,996,205,369.86 төгрөг, 1,707,999.60 ам.долларыг ҮЦГХТ-өөр дамжуулан харилцагчдад төлсөн.

Татан төвлөрүүлсэн нийт хөрөнгийг 2022 оны 2 дугаар сарын 9-ний байдлаар дараах хүснэгтийн дагуу хуваарилан байршуулсан байна:

/тэрбум төгрөгөөр/

Төсөл, хөтөлбөрүүд	Санхүүжүүлэхээр төлөвлөсөн	Санхүүжүүлсэн	Шаардлагатай үлдэгдэл санхүүжилт
Дэд бүтцийн төслүүд:	972.7	274.3	698.4
Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн үлдэгдэл санхүүжилт	601.1	272.5	328.6
Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын холбох холболтын төмөр замын санхүүжилт	65.4	-	65.4
450 МВт-ын хүчин чадалтай Тавантолгойн дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалтын санхүүжилт	306.2	1.8	304.4
Уурхайн хөгжүүлэлт:	371.0	98.6	272.4
Олборлолтын техник, тоног төхөөрөмж худалдан авах санхүүжилт	50.0	33.4	16.6
Төмөр замд нүүрс ачих байгууламжийн бүтээн байгуулалтын санхүүжилт	65.3	65.2	0.1
Өмнөговь аймгийн Цогтцэций, Цогт-Овоо сумдын нутагт орших “Загийн усны хоолой” гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын урьдчилгаа санхүүжилт	16.2	-	16.2
Нүүрс баяжуулах үйлдвэрийн эхний 10 сая тонны блокын санхүүжилт	123.5	-	123.5
Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших “Цагаанцав”-ын гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын санхүүжилт	116.0	-	116.0
Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт:	650.6	319.6	331
Гэрээт олборлогчдын өгөх өглөг	320.6	319.6	1.0



*Handwritten signature*




Өрийн бүтцийн шинэчлэлт	330.0	-	330.0
<b>НИЙТ</b>	<b>1,994.3</b>	<b>692.5</b>	<b>1,301.8</b>

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 2022 оны 2 дугаар сарын 9-ний байдлаар гаргасан ЭТТ Бондыг эх үүсвэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлантай Хавсралт 1-ээс танилцана уу.

Төлөвлөгөөт төслүүдийг санхүүжүүлэх үлдэгдэл 1,301.8 тэрбум төгрөгийг гадаадын хөрөнгө оруулагчдад бондыг санал болгон төвлөрүүлэхээр ажиллаж байна.

Олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлэх, Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан компанийн томоохон төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийг шийдвэрлэх тус төсөл төлөвлөгөөний дагуу явагдаж байна.



СЭХ  
2022-03-23 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE

2022-04-22

БҮРТГЭВ-02

Хавсралт 1

# ЭТТ-БОНД

ЭТТ БОНДЫН ЭХ ҮҮСВЭРЭЭР ТАТАН  
ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН  
ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

/2022 оны 02 дугаар сарын 09-ний байдлаар/

ISO 45001:2018 | ISO 9001:2015 | ISO 14001:2015

2022 ОН

ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ЭТТ

"УУЛ УУРХАЙ - ДЭД БҮТЭЦ - АЖ ҮЙЛДВЭРЛЭЛ"  
ХӨГЖЛИЙН ЖИШИГ - ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ

УЛААНБААТ

ТТГ № 6719





ЭТТ БОНДЫН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

I. ЭТТ Бондын анхдагч зах зээлийн арилжаа

"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/22 тоот тушаал болон "Санхүүгийн Зохицуулах Хороо"-ны 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 96 тоот тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг бүртгэх тухай зөвшөөрөл, "Санхүүгийн Зохицуулах Хороо"-ны 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 1/181 тоот тогтоолоор "Анхдагч зах

зээл дээр арилжаалах" албан ёсны зөвшөөрлийг тус тус олгосноор "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн орлогоор баталгаажсан ЭТТ Бондын I, II дугаар транчийн арилжааг амжилттай зохион байгуулагдаад байна. Үнэт цаасны арилжаанд давхардсан тоогоор нийт 1,467 иргэд, 26 аж ахуйн нэгж оролцож анхдагч зах зээлийн арилжаагаар 692.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Хүснэгт.1 Нийт татан төвлөрүүлсэн дүн

Санхүүжилтийн төрөл	Төгрөгийн бонд	Ам.долларын бонд	НИЙТ
Татан төвлөрүүлсэн дүн	543,427,400,000₮	149,120,547,997₮	692,547,947,997₮

Нийт татан төвлөрүүлсэн дүн /тэрбум төгрөг/



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД



II. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт


"Эрдэнэс Тавантолгой" ХК нь бондыг 3 үе шатаар олон нийтэд санал болгохоор төлөвлөсөн бөгөөд 2021-2024 онд компанийн ашиг, орлогын үзүүлэлтийг нэмэгдүүлэх төслүүдийг

санхүүжүүлэхээр үнэт цаасны танилцуулгад тусгасны дагуу бондын эх үүсвэрээр татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулаад байна.

(2022/02/09-ний байдлаар)




Төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлийн хувь: /тэрбум төгрөг/



Handwritten signature and stamp in red ink.





2022-04-22

БҮРТГЭВ-02



ЭТТ БОНДЫН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

Хүснэгт.2 Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл  
/тэрбум төгрөг/

Төсөл хөтөлбөрүүд	Байршуулах дүн	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн хувь
Дэд бүтцийн төслүүд:	972.7	274.3	28.2%
Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн үлдэгдэл санхүүжилт	601.1	272.5	45.3%
Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын холбох холболтын төмөр замын санхүүжилт	65.4	0.0	0.0%
450 МВт-ын хүчин чадалтай Тавантолгойн дулааны цахилгаан станцын бүтээн байгуулалтын санхүүжилт	306.2	1.8	0.6%
Уурхайн хөгжүүлэлт:	371.0	98.6	26.6%
Олборлолтын техник, тоног төхөөрөмж худалдан авах санхүүжилт	50.0	33.4	66.8%
Төмөр замд нүүрс ачих байгууламжийн бүтээн байгуулалтын санхүүжилт	65.3	65.2	99.9%
Өмнөговь аймгийн Цогтцэций, Цогт-Овоо сумдын нутагт орших "Загийн усны хоолой" гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын урьдчилгаа санхүүжилт	16.2	0.0	0.0%
Нүүрс баяжуулах үйлдвэрийн эхний 10 сая тонны блокын санхүүжилт	123.5	0.0	0.0%
Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших "Цагаанцав"-ын гүний усны ордоос ус татах шугам хоолойн бүтээн байгуулалтын санхүүжилт	116.0	0.0	0.0%
Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт:	650.6	319.6	49.1%
Гэрээт олборлогчдын өгөх өглөг	320.6	319.6	99.7%
Өрийн бүтцийн шинэчлэлт	330.0	0.0	0.0%
НИЙТ	1994.3	692.5	34.7%

ЗАРЦУУЛАЛТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

1. ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮД

1.1. ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯАН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМ

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд доод бүтэц, гүүрний барилга угсралтын ажил бүрэн дууссан бол эрчим хүч, шилэн кабель, замын тэмдэг тэмдэглэгээ зэрэг ажлууд 98.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төмөр замын дэд бүтцийн барилга, угсралтын ажлын хувьд Цогтцэций сумын ертөөний барилга, ажилчдын орон сууц 6 зөрлөгийн барилга, эрчим хүчний шугам, шилэн кабел зэрэг ажлууд бүрэн дууссан. Нийт 463.5 км төмөр зам баригдахаас 443.9 км бетон дээр, зам төмөр угсрах ажил хийгдээд байгаа ба 98.8 хувийн гүйцэтгэлтэйгээр 123 машин механизм, 456 ажиллах хүчний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг 2022 оны II улиралд бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.





ЭТТ БОНДЫН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

2022/02/09-ний байдлаар

Гүйцэтгэх ажил	Гүйцэтгэл
Доод бүтцийн барилга угсралтын ажил:	
Газар шорооны ажил	100.0%
Хоолой /596 байршилд/	100.0%
Худгийн ажил	100.0%
Гүүр /26 байршилд/	100.0%
Гүүр /1 байршилд/	100.0%
Дээд бүтцийн барилга угсралтын ажил	98.8%
Өртөөний барилга угсралтын ажил	100.0%



ТӨСЛИЙН АЧ ХОЛВОГДОЛ:

Тус төмөр замаар тээвэрлэх ачаа тээврийн эргэлтийг жилд дунджаар 15 сая тоннд хүргэж, шинээр 1,200 үндсэн ажлын байр бий болгож,


ачаа тээвэрлэлтээс жилд дунджаар 675 тэрбум төгрөгийн тээврийн орлоготой, 175 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллах төсөл юм.

ТӨСЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Төмөр замын урт	414.6 км урт
Хүчин чадал	15 сая тонн/жил
Цариг, зэрэглэл	1,520 мм өргөн, 3-р зэрэглэл
Тариф	\$0.035 тн/км ~\$14.5 тн
Хөрөнгө оруулалт	₮1,881.1 тэрбум FS=₮2,853.3
NPV	₮273.9 тэрбум
IRR	8.9%
X/O нөхөх хугацаа	12 жил

1.2. ТАВАНТОЛГОЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ


"Тавантолгой дулааны цахилгаан станц" ТӨХХК нь 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулагдсан ба одоогоор төслийн суурь бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 175 дугаар тогтоолоор тус компанийн 30%-ийг "Эрдэнэс Тавантолгой" ХК эзэмшихээр заасан. Одоогоор төслийн бүтээн байгуулалтыг эхлүүлэхэд шаардлагатай бэлтгэл ажлууд болох газар эзэмшил, барилга угсралтын дэд бүтцийн хангамж, барилга угсралтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зэрэг бэлтгэл ажлууд хийгдэж байна. Тавантолгой цахилгаан станцыг барьж байгуулах нь өмнийн говийн уул уурхайн эрчим хүчний хэрэглээг найдвартай эрчим хүчний эх үүсгүүрээс



хангах, цахилгаан станцын үйл ажиллагааны гол зардал болох нүүрсний тээвэрлэлтийн зардлыг хэмнэх, тус бүс нутгийн эрчим хүчний системийн горимыг тогтворжуулж, найдвартай ажиллагааг сайжруулах зэрэг ач холбогдолтой төсөл болно.

Handwritten signature in red ink.





2022-04-22

БҮРТГЭВ-02



ЭТТ БОНДЫН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

ТӨСЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Хүчин чадал	3x150МВт
Станцын цэвэр цахилгаан үйлдвэрлэл	2.8 тэрбум кВт/ц
Нүүрсний хэрэглээ	1.4 сая.тн/жил
Ажиллах хүчний тоо	230 байнгын ажлын байр
Нийт төсөвт өртөг	\$808.2 сая
Эрчим хүчний өртөг	0.031 \$/кВт цаг
NPV	₮734,3 сая
IRR	11.4%
Х/О нөхөх хугацаа	9.4 жил

2. УУРХАЙН ХӨГЖҮҮЛЭЛТ

2.1. ТӨМӨР ЗАМД НҮҮРС АЧИХ БАЙГУУЛАМЖИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

"Эрдэнэс Тавантолгой" ХК нь УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрийн дагуу хэрэгжүүлж буй томоохон авто болон төмөр замын төслүүдтэй уялдуулан Тавантолгой нүүрсний ордыг түшиглэн нүүрс ачиж, тээвэрлэх иж бүрэн байгууламж барьж байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлжээр төлөвлөн ажиллаж байна.

Засгийн Газрын 2020 оны 113 дугаар тогтоолын дагуу Тавантолгой ордын Цанхийн уурхайгаас нүүрс ачиж, тээвэрлэх ачилтын тойрог төмөр замын газар шорооны ажлыг "Тавантолгой Төмөр Зам" ХХК хариуцан ажиллаж байна. Барилга, угсралтын ажлыг 2020 оны 9 дүгээр сард эхлүүлсэн.

Төслийн ажилтай холбоотой Төмөр замын тээврийн тухай хууль болон холбогдох төмөр замын тээврийн нийтлэг багц дүрэм, стандартад заасны дагуу 2020 оны 11 дүгээр сараас өөрийн охин компани болох "Тавантолгой төмөр зам" ХХК-д хариуцуулан төмөр замын ачих байгууламжийн төслийн ТЭЗҮ, судалгааны ажлыг эхлүүлсэн.

Одоогоор "Тавантолгой төмөр зам" ХХК нь дээрх төмөр зам болон авто замд ачилт хийх байгууламжийн бэлтгэл ажлууд болох ТЭЗҮ, зураг төсөл болон байгаль орчны нарийвчилсан үнэлгээ боловсруулах ажлууд хийгдэж байна.



ТӨСЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ:

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын техник эдийн засгийн үндэслэлд Тавантолгой уурхайн нүүрсийг вагонд бункерийн байгууламжаар ачих зорилгоор Тавантолгой өртөөтэй холбогдож буй ачилтын тойргийг хос замтай барихаар тусгасан. Тавантолгой- Зүүнбаян чиглэлийн

төмөр замын техник, эдийн засгийн үндэслэлийн тодотголд Цогтцэций өртөөг төлөвлөхдөө нүүрс ачих байгууламжтай холбох хэсгийг багтаагаагүй тул Цогтцэций өртөөг Тавантолгой өртөөтэй холбох төмөр замыг барьснаар ачааны эх үүсвэртэйгээ холбогдох ач холбогдолтой.



*Handwritten signature in black ink.*

*Handwritten signature in black ink.*

СЭХ  
2022 оны 03 23 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2022-04-22  
БҮРТГЭВ-02



ЭТТ БОНДЫН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

2.2. НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЭХНИЙ 10 САЯ ТОННЫ БЛОК

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монгол Улсын Их Хурал, За сгийн газрын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд коксжих чанар султай нүүрсийг сайн чанарын нүүрсгэй хольж баяжуулан чанарыг дундажлан экспортын шаардлага хангасан,

орчин үеийн, дэвшилтэт техник, технологи бүхий “Нүүрс баяжуулах үйлдвэр”-ийг жилд 30 сая.тн хүртэлх нүүрс баяжуулах хүчин чадалтайгаар хоёр үе шаттай барьж байгуулахаар барихаар төлөвлөсөн.

Нүүрс баяжуулах үйлдвэрийн 3D төлөвлөлт



ЕРС гэрээлэгч буюу түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр төслийг бүхлээр нь барьж ашиглалтад оруулж хүлээлгэн өгөх компанийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендерийг 2021 оны 11 дугаар сарын 15-ны

өдөр зарласан бөгөөд 12 дугаар сарын 15-ны өдөр дуусгавар болж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан бөгөөд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахаар ажиллаж байна.

ТӨСЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ:

Нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор жилд дунджаар 23.8 сая.тн хатуу коксжих болон хагас зөөлөн коксжих нүүрсний баяжмалыг экспортонд гаргаж, 1.5 сая.тн завсрын

бүтээгдэхүүнийг Тавантолгойн 450МВт-ын дулааны цахилгаан станцад борлуулах бөгөөд жилд дунджаар 2.1 тэрбум ам.долларын борлуулалтын орлого олохоор байна.

ТӨСЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Жилийн хүчин чадал	Нийт 30 сая тн 1 блок=10 сая
Усны хэрэглээ	54.6 л/с
Цахилгааны хэрэглээ	6.71 кВт цаг/тн
ОРЕХ	\$4.8 тонн
CAPEX	\$335 сая /1 блок/
NPV	\$911.7 сая
IRR	23.9%
X/O нөхөх хугацаа	7 жил

Төсөл хэрэгжсэнээр 472-928 шууд ажлын байр шинээр бий болж, жилд дунджаар 185.5 сая ам.долларыг улс орон нутгийн төсөвт төвлөрүүлж, улмаар ордын нөөцийг хаягдал багатай, иж бүрэн ашиглах, экспортыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний

чанарт тавигдах шаардлагыг оновчтой байдлаар хангах, экологийн сөрөг нөлөөллийг бууруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашиг ихээхэн нэмэгдэх зэрэг олон ач холбогдолтой.

Handwritten signature and stamp in the bottom left corner.

Stamp and signature in the bottom right corner.




ЭТТ БОНДЫН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

2.4. “ЗАГИЙН УСНЫ ХООЛОЙ” ГҮНИЙ УСНЫ ОРДООС УС ТАТАХ ШУГАМ ХООЛОЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн цаашид төлөвлөж буй үйлдвэрлэлийн болон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлж эхэлснээр усны хэрэглээ ойрын хугацаанд хэд дахин нэмэгдэх ба уг хэрэгцээг хангах зорилгоор БОАЖЯ-ны дэргэдэх Усны нөөцийн зөвлөлөөс “Загийн усны хоолой” хэсэгт шинээр тогтоосон гүний усны нөөцийг нүүрс баяжуулах үйлдвэрийн усны хэрэгцээнд ашиглуулахыг зөвшөөрч улмаар компанийн зүгээс “Усны тухай хууль”-ийн дагуу дээрх усыг ашиглах дүгнэлт, холбогдох зөвшөөрлийг

холбогдох газруудаас тус тус авсан. Уг төсөлд “Загийн усны хоолой”-н газрын доорх усыг Тавантолгойн нүүрсний уурхайд хүргэх ус хангамжийн системийг гүний худгууд, ус цуглуулах шугам, өргөлтийн насос станцууд, гол шугам хоолой, хиймэл нуур гэсэн байгууламжуудтай байхаар төлөвлөсөн. Загийн усны хоолойгоос шугам хоолой татах барилгын зураг төслийн ажлын хүлээн авсан бөгөөд барилга угсралтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааны баримт бичгийг боловсруулж байна.

Загийн усны хоолойн байршил



ТӨСЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ:

Загийн усны хоолойн усан хангамжийн төслийг хэрэгжүүлснээр Таван толгойн уул уурхайн үйлдвэрлэлийн ус хэрэглээний нормоор тооцсон усны нийт хэрэгцээний 8-10%-ийг хангах боломж бүрдэх бөгөөд энэ нь эхний үед үйлдвэрлэлийн хэрэгцээг хангах боломжтой.

ТӨСЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Усны нөөц	63.65 л/с
Ус дамжуулах шугам	72.6 км хоолой, 14 гүний худаг, 2 өргөх насос
Хөрөнгө оруулалт	\$41.7 сая
Үйл ажиллагааны зардал	\$15/м3
NPV,	₮3,5 тэрбум
IRR	4,36%


Энэхүү төсөл нь Тавантолгойд шаардлагатай усны асуудал бүрэн шийдвэрлэгдэх хүртэл усны хэрэгцээг хангах төдийгүй гадаргын болон газрын доорх усны эх үүсвэрийг хослуулан хэрэглэхэд дэмжлэг үзүүлэх ач холбогдолтой.

Handwritten signature in red ink.



СЭХ  
2022.03.23 өдөр  
БҮРТГЭВ  
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
MONGOLIAN STOCK EXCHANGE  
2022-04-22  
БҮРТГЭВ-02



7505 5555 | www.ett.mn | info@erdenestt.mn | erdenestt | erdenestt

*Handwritten signature in black ink.*

УЦК ХХК  
ТТГ № 6719  
*Handwritten signature in black ink.*